



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 06 сарын 17 өдөр

Дугаар А/438

Булган сум

Малын гоц халдварт шүлхий
өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг
эрчимжүүлж, малын шилжилт хөдөлгөөнийг
түр хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 46 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 3 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өлгий аймгийн төв, Алтай, Дэлүүн, Ховд аймгийн Булган, Үенч сумдад малын гоц халдварт шүлхий өвчний SAT-1 хэвшил, Дорнод аймгийн Баянтүмэн суманд шүлхий өвчний О хэвшил, Дорноговь аймагт ямааны годрон өвчин тус тус оношлогдон батлагдсантай холбогдуулан эдгээр өвчин аймгийн нутаг дэвсгэрт нэвтрэн тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эрсдэл бүхий бүс нутгаас Булган аймаг руу амьд мал шилжүүлэн оруулах, тууварлах хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглосугай.

2.Булган аймгийн Сайхан сум болон өвчний эрсдэл бүхий бүс нутгуудад малын гоц халдварт өвчнийг эрт илрүүлэх үзлэг, тандалт, судалгаа, яаралтай дархлаажуулалт, халдваргүйтгэл, хорио цээр болон хязгаарлалтын дэглэмийн хэрэгжилтийг ханган ажиллахыг сумын Засаг дарга нар болон Мал эмнэлгийн газрын дарга (Г.Одсүрэн)-д тус тус даалгасугай.

3.Зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж, холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр)-т даалгасугай.

4.Архангай, Өвөрхангай, Төв, Орхон, Хөвсгөл аймагтай хил залгаа сумдын чиглэлд мал тээвэрлэх, тууварлах, отор нүүдэл хийх болон малчдын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтыг эрчимжүүлж, хууль тогтоомж болон энэхүү захирамжийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд холбогдох арга хэмжээ авч

ажиллахыг Цагдаагийн газрын дарга (хурандаа Б.Эрдэнэбилэг), Мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч нарт үүрэг болгосугай.

5.Малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмжийг иргэд, малчдад шуурхай хүргэж, өвчний эрсдэл, хор уршгийн талаар мэдээлэл сурталчилгааг тогтмол зохион байгуулахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн), сумын Засаг дарга нарт даалгасугай.

6.Аймаг, сумын хэмжээнд зохион байгуулагдах хурдан морины бүсийн уралдаан болон олон тооны мал төвлөрүүлэх арга хэмжээг нөхцөл байдал хэвийн болох хүртэл хязгаарлах зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Морин спорт, уяачдын холбоо (Б.Гүндсамбуу), сумын Засаг дарга нарт даалгасугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд аймгийн Шуурхай штабын хурлыг тухай бүр зохион байгуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР